267.	Ган, зудаас урьдчилан сэргийлэх тогтолцоо бий болгож, бэлэн байдлын нөөцийн хэмжээг шинэчлэн тогтоох. Газар хөдөлт болон бусад гамшгийн мэдээлэл, судалгааны газрын хүчин чадал, техник, технологийг шинэчилнэ.	1	Эрдэнэт, Дархан, Хархорин, Ховд, Улиастай, Зуунмод болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдөлтийн эрсдэлийн үнэлгээ хийнэ.	2012-2014	БХБЯ		АНЗД ТББ	5.000.0	Эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.
		2	Газар хөдөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийнэ.	2012-2014	БХБЯ		ТББ	5.000.0	Судалгаануудыг хийсэн байна.
		3	Эрдэнэт, Дархан, Хархорин, Ховд, Улиастай, Зуунмод болон Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт газар хөдөлтийн эрсдэлийн үнэлгээ хийнэ.	2012-2014	БХБЯ		Холбогдох АЗД НЗД ТББ	5.000.0	Эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.
		4	Газар хөдөлтийн гамшгийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдөлт, тектоникийн судалгааны ажлыг орчин үеийн технологийн түвшинд хийнэ.	2012-2014	БХБЯ		ТББ	5.000.0	Судалгаануудыг хийсэн байна.
		5	Барилга байгууламжийг загварчилж бодит байдалд турших, дүн шинжилгээ хийх, барилгын бүтээц болон түүний элементийг газар хөдөлтөд турших, багаж, тоног төхөөрөмж бүхий лабораторитой болж, туршилтын багаж, тоног төхөөрөмжийг шинэчилнэ.	2012-2014	БХБЯ			5.000.0	Лаборатори байгуулагдсан байна.
		6	Улаанбаатар хотын эрсдэлтэй бүсүүдийн зургийг гаргах, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах, гамшгийн эрсдэлийн мэдээллийн санг байгуулах, орон нутгийн иргэдийг цаг уурын эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авах, зудын урьдчилсан мэдээ гаргах мэдээллийн систем боловсруулах, малын тэжээлийн нөөц бэлтгэх, хадгалах, хуваарилах тогтолцоог бий болгох төсөл хэрэгжүүлнэ.	2012-2014	НЗД	СЯ		2.73 сая ам.доллар ДБ-ны буцалтгүй тусламж	Төслийг хэрэгжүүлсэн байна.
		7	"Бага оврын сансрын холбооны хиймэл дагуул" төсөл хэрэгжүүлнэ.	2012-2018	МТШХХГ	УУЯ ҮХААЯ БХБЯ		500.000.0 Улсын төсөв Гадаадын зээл	Төслийг хэрэгжүүлсэн байна.
		8	Газар хөдөлтийн гамшгаас амжиж анхааруулах системийг улсын хэмжээнд байгуулна.	2012-2013	МТШХХГ	ОБЕГ	ХХ	11.400.0 Улсын төсөв	Анхааруулах системийг байгуулсан байна.

		9	Баглаа боодлын шинэ технологи нэвтрүүлэн овор багатай чанар сайтай тэжээл бэлтгэж, улсын болон орон нутгийн байнгын нөөц бүрдүүлэх, агуулахын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	ОБЕГ	АНЗД	6.200.0 Улсын төсөв	Технологийг нэвтрүүлж, нөөцийн хэмжээ нэмэгдсэн байна.
		10	Улс, аймаг, сум бүрийг цаг хүндэрсэн үед ашиглах нөөц бэлчээртэй болгох арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2013-2016	ҮХААЯ	БОНХЯ ОБЕГ	АНЗД	3.000.0 Улсын төсөв	Нийт бэлчээрийн 10-аас доошгүй хувийг нөөцөд авсан байна.
268.	Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмийн хаягдал булшлахыг хориглоно.	1	Ашигласан түлш болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй байдлын тухай конвенцид нэгдэн орж Цөмийн хаягдлын талаар Монгол Улсын баримталж байгаа бодлого, хууль эрх зүйн холбогдох баримт бичгийн хэрэгжилтийг хангана.	2012-2014	ЦЭГ	ГХЯ ХЗЯ			Конвенцид нэгдэн орсон байна.
		2	Хилийн боомтууд дахь цацрагийн хяналтын техник, тоног төхөөрөмжийг орчин үеийн шаардлагад нийцүүлэн шинэчилж, хүний нөөцийн чадавхийг сайжруулна.	2013-2014	ЦЭГ	МХЕГ ХХЕГ	АНУ-ын ЭХЯ-ны төсөл		Техник, тоног төхөөрөмж, хүний нөөцийн чадавхийг сайжруулсан байна.
269.	Цөмийн энергийн чиглэлээр явуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр “Шар нунтаг”-аас цааш үргэлжлэхгүй байхыг хуульчлан тогтоох	1	Монгол Улсын төрөөс цацраг идэвхит ашигт малтмал, цөмийн энергийн талаар баримтлах бодлого, холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулна.	2012-2013	ЦЭГ	ХЗЯ			Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.
270.	Стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, хүнсний аюулгүй байдлыг хангахуйц тээвэр, агуулахын сүлжээ, ложистик байгуулахыг дэмжих	1	Бөөний худалдааны төв, захуудын хөргөлттэй агуулах, лангуу, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгслийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлнэ.	2014-2015	ҮХААЯ	СЯ ЭЗХЯ		5.000.0 Улсын төсөв	Зээл олгосон байна.
		2	Стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүний хэрэглээг дэмжиж, зах зээлд чанар, аюулгүй байдлын баталгаатай бүтээдэхүүн нийлүүлэхийг дэмжих зорилгоор чанартай бүтээгдэхүүнд олгох шалгуур, шагнал урамшууллыг бий болгох арга хэмжээ авна.	2012-2016	СХЗГ	ҮХААЯ МХЕГ	ТББ	Улсын төсөв	Шалгуур, шагнал урамшууллыг бий болгосон байна.
271.	Малын хулгайтай тэмцэх асуудлын хүрээнд байнгын ажиллагаатай цахим сүлжээ, лавлах утас ажиллуулан үнэн зөв мэдээлэл өгсөн иргэдийг урамшуулдаг тогтолцоо бүрдүүлэх	1	Малын хулгайтай тэмцэх асуудлын хүрээнд байнгын ажиллагаатай цахим сүлжээ нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	2013-2014	ХЗЯ		АНЗД	4.000.0	Цахим сүлжээ бий болж, мэдээллийн шуурхай байдал хангагдсан байна.
		2	Малын хулгайн гэмт хэргийн талаар мэдээлэл авах лавлах утас ажиллуулна.	2013	ХЗЯ	ҮХААЯ	ТББ		Мэдээлэл авах утас ажилладаг болсон байна.

		3	Малын хулгайн талаар үнэн зөв мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах асуудлыг шийдвэрлэнэ.	2013	ХЗЯ		ТББ		Урамшуулал олгодог болсон байна.
272.	Хар тамхи, хүний болон зэвсгийн наймааны гэмт хэрэгтэй тэмцэх асуудлаар тусгай боловсон хүчин бэлтгэх, гадаад улсын туршлага судлах, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааг сайжруулах	1	Мөрдөх алба байгуулж, мөрдөгчийг чадавхижуулан, сургаж бэлтгэх зорилго бүхий Мөрдөгчийн сургууль байгуулна.	2014	ХЗЯ			120.000.0	Мөрдөгчийн сургууль байгуулагдсан байна.
		2	Гадаад улсын ижил төрлийн сургуульд мөрдөгчийг сургах ажлыг зохион байгуулна.	2015	ХЗЯ			10.000.0	Бусад орны сургуульд мөрдөгчдийг сургаж эхэлсэн байна.
		3	Хууль сахиулах, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тусгай мэдээллийн сан бүрдүүлж, байгууллага хооронд мэдээлэл солилцох сүлжээ бий болгоно.	2015	ХЗЯ			10.000.0	Мэдээллийн сан бүрдэж, мэдээлэл солилцох сүлжээтэй болсон байна.
		4	Хар тамхитай тэмцэх чиглэлээр гадаад орны холбогдох албадтай нягт хамтын ажиллагааг хөгжүүлж, мэргэжлийн дэмжлэг туслалцаа авч ажиллана.	2012-2016	ТЕГ				Хамтын ажиллагаа өргөжсөн байна.
		5	Олон улсын болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг хөгжүүлж, ажилтнуудыг энэ чиглэлээр гадаад, дотоодын сургалтад хамруулна.	2012-2016	ТЕГ	ГХЯ ХЗЯ			Ажилтнуудыг сургалтад хамруулсан байна.
273.	“Архигүй монгол хүн” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	1	“Архигүй Монгол хүн” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.	2013-2016	ХЗЯ	ҮХААЯ ЕТГ	АНЗД ТББ	20.000.0	Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн байна.
		2	Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны журмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		3	Согтууруулах ундаатай холбоотой хууль эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх талаар судалгаа хийнэ.	2013	ҮХААЯ	ХЗЯ СЯ ГХЯ ЭЗХЯ		0.38	Судалгаа хийгдсэн байна.
		4	Спиртийн үйлдвэрт тавих төрийн хяналтыг сайжруулж, татварын хэмжээг үе шаттай нэмэгдүүлэх замаар өндөр хатуулагтай согтууруулах ундааны үйлдвэрлэлийг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2012-2014	ҮХААЯ	СЯ МХЕГ ТЕГ ГЕГ			Согтууруулах ундааны үйлдвэрлэл буурсан байна.
		5	Архи, спиртийн болон хүнсний бусад шингэний тоолуур шалгах зориулалттай суурин эталон тоног төхөөрөмж бүхий лаборатори байгуулна.	2013-2015	СХЗГ	ҮХААЯ		600.0 Улсын төсөв	Лаборатори байгуулагдсан байна.

ТАВ. ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН									
274.	Төр засгийг иргэдэд нээлттэй, тунгалаг болгох цогц арга хэмжээ авах	1	Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хуульд болон түүнтэй холбогдуулан бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна.	2012	ЗГХЭГ				Хуулиуд батлагдсан байна.
		2	Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг УИХ-аар батлуулж, Засгийн газрын агентлагийг байгуулах, өөрчлөн байгуулах асуудлыг шийдвэрлэж, байршлыг тогтоон ажиллуулна.	2012	ЗГХЭГ	Яам агентлаг			Тогтоол батлагдсан байна.
		3	Яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	2012	ЗГХЭГ	Яам			Засгийн газрын тогтоол, хөтөлбөр, орон тоог баталсан байна.
		4	Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийн ерөнхий загвар болон агентлаг бүрийн орон тооны дээд хязгаарыг баталж, мөрдүүлнэ.	2012	Яам	ЗГХЭГ			Хөтөлбөр, бүтэц, орон тоо батлагдсан байна.
		5	Засгийн газраас байгуулсан хороо, зөвлөл, ажлын албадыг өөрчлөн зохион байгуулж ажиллуулна.	2012	ЗГХЭГ	Яам			Засгийн газрын тогтоол гарсан байна.
		6	Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулж сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагыг байгуулах, өөрчлөн зохион байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.	2012	Яам	ЗГХЭГ			Засгийн газрын тогтоол гарсан байна.
		7	Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, шийдвэрлэх, хариу өгөх, хяналт тавих бүх үе шат нь өргөдөл, гомдол гаргагчид ил тод байдаг мэдээллийн систем нэвтрүүлнэ.	2013-2014	МТШХХГ		ХХ	1.300.0 Улсын төсөв	Мэдээллийн системийг нэвтрүүлсэн байна.
		8	Төрийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хяналт-шинжилгээ үнэлгээний чадавхийг сайжруулна.	2012-2016	ЗГХЭГ	Яам Агентлаг	АНЗД		Эрх зүйн орчныг боловсронгуй болгож, чадавхийг сайжруулсан байна.
		9	Үндэсний дата төвийг тоноглож, нөөц төв байгуулна.	2013-2015	МТШХХГ	ТЕГ		43.000.0 Улсын төсөв Гадаадын зээл	Төвийг тоноглож, Нөөц төвийг байгуулсан байна.
		10	Улаанбаатар хотод төрийн байгууллагуудыг холбосон өндөр хурдны суурь сүлжээ байгуулна.	2012-2016	МТШХХГ	ТЕГ		23.040.0 Улсын төсөв	Суурь сүлжээг байгуулсан байна.

		11	Хөдөлгөөнт холбооны технологид суурилсан төрийн үйлчилгээг бий болгоно.	2013-2014	МТШХХГ		ХХ	3.250.0 Улсын төсөв	Үйлчилгээг бий болгосон байна.
		12	Төрийн үйлчилгээний нэгдсэн портал сайт бий болгоно.	2013-2018	МТШХХГ		ХХ	2.000.0 ТХХТ Гадаадын тусламж	Нэгдсэн портал сайттай болсон байна.
275.	Төрийн албыг нийтийн алба болгон өөрчлөх	1	Чадахуйн зарчим /мерит/-д суурилсан, улс төрөөс хараат бус, шударга, ил тод, хариуцлагатай нийтийн албаны эрх зүйн үндсийг тогтоож, мэргэшсэн, тогтвортой нийтийн албыг хөгжүүлэх зорилгоор Нийтийн албаны тухай хуулийн төслийг боловсруулна.	2012-2013	ЗГХЭГ	ХЗЯ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
276.	Улс төрийн намыг нийтийн хөгжлийн зүй тогтолтой уялдуулан төлөвшүүлэн хөгжүүлэх чиглэлээр шинэчлэл хийх	1	Улс төрийн нам, эвсэл, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо, саналд тулгуурлан Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг санаачлан боловсруулна.	2012-2013	ЗГХЭГ	ХЗЯ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
277.	Зөвшөөрөл, лицензийн тоог эрс цөөлж, зөвшөөрөл, лиценз авдаг олон шат, дамжлагыг энгийн хэлбэрт оруулах	1	Зөвшөөрөл, лицензийн тоог цөөлөх, олгох журам, шат, дамжлагыг хялбаршуулж энгийн болгох чиглэлээр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай болон холбогдох бусад хуульд өөрчлөлт оруулна.	2012-2013	ЗГХЭГ	ХЗЯ			Хуульд өөрчлөлт оруулсан байна.
		2	Зөвшөөрөл, лицензийн тоог нэмэгдүүлэхгүй байх, олгох журам, шат, дамжлагыг хялбаршуулж энгийн болгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, байнгын хяналт тавих чиг үүрэг бүхий Засгийн газрын комиссыг байгуулж ажиллуулна.	2012-2013	ЗГХЭГ	Яам агентлаг			Засгийн газрын комисс байгуулагдсан байна.
		3	Зөвшөөрөл, лицензийн электрон нэгдсэн портал хуудас нээж ажиллуулна.	2012-2013	МТШХХГ	Яам агентлаг			Портал хуудсыг нээн ажиллуулсан байна.
		4	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны цахим үйлчилгээний хэлбэрт бүрэн шилжинэ.	2012-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ		10.0 Гадаадын зээл	Цахим үйлчилгээний хэлбэрт бүрэн шилжүүлсэн байна.
		5	Хуульд зааснаас бусад тохиолдолд төрийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага аж ахуйн аливаа үйл ажиллагаатай холбогдсон зөвшөөрөл, лиценз, эрх олгох, бүртгэл явуулах, төлбөр, хураамж авч байгаа байдалд тогтмол хяналт тавьж, зөрчлийг арилгуулж байна.	2013-2016	ШӨХТГ	ХЗЯ Холбогдох яам МХЕГ		Улсын төсөв	Хяналт сайжирч, зөрчил буурсан байна.
		6	Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын тусгай	2012-2016	БХБЯ		ТББ		Гадаад орны туршлагыг

			зөвшөөрөл олгох үйл ажиллагааг Төрийн бус байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх, салбарын хэмжээнд тусгай зөвшөөрөлгүй болгох талаар гадаад орны туршлагыг судалж нэвтрүүлнэ.						судалж, нэвтрүүлсэн байна.
		7	Барилга, хот байгуулалт, газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарт зайлшгүй шаардлагатай тусгай зөвшөөрөл, лиценз олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллана.	2012-2014	БХБЯ		ТББ	1.000.000 Улсын төсөв	Тусгай зөвшөөрөл, лизенц олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.
278.	Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлснээр иргэн зөвхөн нэг цонхоор, нийтийн нэг албан хаагчтай харьцах зарчмыг тогтоож, бусад шат дамжлагад төрийн байгууллагууд хоорондоо харьцах замаар иргэдэд үйлчлэх	1	Төрийн үйлчилгээнд цахим программ хангамж бүхий нээлттэй үйлчилгээг нэвтрүүлж, иргэдээс байгууллага, албан хаагчдад хандаж тавьсан хүсэлт, саналыг хүлээн авсан ажилтан өөрөө хариуцан бусад төрийн байгууллага, ажилтантай цахим шуудангаар хууль тогтоомжийн дагуу харилцаж хариу авч, хүсэлт гаргасан иргэнд үйлчилдэг тогтолцоонд шилжин хэрэгжүүлнэ.	2012-2016	Яам	Агентлаг	АНЗД Төсөвт байгууллага		Тогтолцоонд бүрэн шилжсэн байна.
		2	Засгийн газар, яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр иргэдийн хүсэлт, санал, гомдлыг хүлээн авах “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлэн хариу өгдөг журамд бүрэн шилжинэ.	2012-2016	ЗГХЭГ	Агентлаг	АНЗД Төсөвт байгууллага		Журамд бүрэн шилжсэн байна.
		3	Улсын хэмжээнд байгуулагдсан “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвүүдийн үйл ажиллагааг бэхжүүлж, тогтвортой явуулах зорилгоор тэдгээрийг нутгийн захиргааны байгууллагын бүтцийн нэгж болгож, шаардагдах хөрөнгийг орон нутгийн төсөвт тусгана.	2012	ЗГХЭГ	АНЗД	ХАБСТ		“НЦҮ”-ний төвийг нутгийн захиргааны байгууллагын бүтцэд оруулж, төсвийг шийдвэрлэсэн байна.
		4	Төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх ажлын хүрээнд үйлчилгээ үзүүлж байгаа “НЦҮ”-ний ажилтнууд яам, агентлагийн холбогдох мэдээллийн сан болон улсын бүртгэлийн байгууллагын дундын өгөгдлийн сангийн мэдээллийг ашиглан үйлчилгээ үзүүлэх боломжийг судалж, нэвтрүүлж эхэлнэ.	2012-2016	ЗГХЭГ	Холбогдох яам агентлаг	ХАБСТ		Шинэлэг, дэвшилтэт үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн байна.

		5	Цахим гарын үсэг, цахим иргэний үнэмлэхийг ашиглан үзүүлэх үйлчилгээг нэвтрүүлж шат дамжлагыг цөөлөх, хялбарчлах арга хэмжээ авна.	2012-2016	ЗГХЭГ	МТШХХГ Холбогдох яам агентлаг	ХАБСТ		Үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн байна.
279.	Төрийн үйлчилгээ хүргэж байгаа төрийн байгууллага хуулиар тогтоосон хугацаанд хариу өгөөгүй тохиолдолд зөвшөөрсөнд тооцох зарчмыг шинээр нэвтрүүлэх	1	Нийтийн албан хаагч хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж, иргэдэд ялгаварлалгүйгээр, шуурхай үйлчлэх шаардлагын хэм хэмжээг тогтоож, үйлчилгээний үр ашиг, үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн Нийтийн албаны үйлчилгээний стандарт, уг стандартыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээг тогтоох эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2012-2016	ЗГХЭГ	ХЗЯ			Эрх зүйн орчин бүрдсэн байна.
		2	Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа нийтийн албаны байгууллага, албан хаагч хуулиар тогтоосон хугацаанд зохих журмын дагуу хариу өгөөгүй тохиолдолд зөвшөөрсөнд тооцох зарчмыг холбогдох хууль тогтоомж болон Нийтийн албаны үйлчилгээний стандартад тусгаж хэрэгжүүлнэ.	2012-2016	ЗГХЭГ	ХЗЯ			Зарчмыг хууль тогтоомж, стандартад тусган хэрэгжүүлж эхэлсэн байна.
280.	Европын Холбоо, АНУ, ISO-ийн стандартыг хангасан бүтээгдэхүүнд шууд зөвшөөрөл олгодог болох	1	Эрчим хүчний салбарт Европын холбооны стандартыг нэвтрүүлнэ.	2012-2016	ЭХЯ	ЭЗХЯ СЯ		50.0 Гадаад зээл	Стандартуудыг хөгжингүй орнуудын жишигт хүргэсэн байна.
		2	Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг шинэчлэн боловсруулна.	2012-2013	СХЗГ	ХЗЯ	ТББ		Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		3	ЕХ, АНУ, ISO-ийн стандарт хангасан бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх үед холбогдох мэдээллийг авсны үндсэн дээр баталгаажуулалт, сорилт шинжилгээ хийхээс чөлөөлдөг тогтолцоонд шилжинэ.	2013-2016	СХЗГ	ГЕГ МХЕГ МҮХАҮТ	ТББ	Улсын төсөв	Тогтолцоонд шилжсэн байна.
		4	“Хэмжих хэрэгслийн загварын туршилтын үр дүнг Харилцан Хүлээн зөвшөөрөх Хэлэлцээр”, “Хэмжлийн нэгжийн үндэсний эталон, Хэмжил зүйн үндэсний хүрээлэнгүүдээс олгож байгаа шалгалт тохируулгын болон хэмжлийн үр дүнгийн гэрчилгээг Харилцан Хүлээн зөвшөөрөх Хэлэлцээр”-т нэгдэн орно.	2012-2016	СХЗГ	ГХЯ		40.0 Жил бүр	Хэлэлцээрт нэгдэн орсон байна.
		5	Ус, цахилгаан болон дулааны тоолуурын анхдагч баталгаажуулалтын үр дүнг шууд хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг БНХАУ, ОХУ, ХБНГУ, БНСУ-ын хэмжил зүйн төв байгууллагатай байгуулан ажиллана.	2012-2014	СХЗГ	ГХЯ		20.0 Улсын төсөв Жил бүр	Хэлэлцээрийг байгуулсан байна.

		6	Тохирлын баталгаажуулалтад хамруулахтай холбогдолтой баримт бичиг, мэдээ судалгааг цахим хэлбэрээр авч мэдээллийн сан бүрдүүлж ажиллана.	2013-2016	СХЗГ	ГЕГ МХЕГ МҮХАҮТ	ТББ	Улсын төсөв	Мэдээллийн сантай болсон байна.
281.	Мэдээллийн технологийг ашиглан цаасаар үйлддэг шат дамжлагыг 50 хувиар бууруулах	1	Орчин үеийн шинэ технологи болох Үүлэн тооцооллыг /Клауд компьютинг/ нэвтрүүлж, цахим-офисын орчин бүрдүүлнэ.	2013-2014	МТШХХГ	Төрийн байгууллага	ХХ	1.840.0 Улсын төсөв Гадаадын зээл	Цахим офисын орчин бүрдсэн байна.
		2	Байгууллага хооронд мэдээлэл дамжуулах үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, программ хангамж, техник хэрэгслийг сайжруулах арга хэмжээ авна.	2013-2016	СХЗГ	ГЕГ МХЕГ МҮХАҮТ	ТББ	Улсын төсөв	Байгууллага хоорондын мэдээлэл дамжуулах цахим үйлчилгээг бий болгосон байна.
282.	Бизнес болон хөрөнгийн бүртгэлийг долоо хоногийн дотор бүртгэдэг тогтолцоог нэвтрүүлэх	1	Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эд хөрөнгийн бүртгэлийг долоо хоногийн дотор бүртгэдэг эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
283.	“Цахим засаглал” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1	Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Цахим засаглал, Цахим эрүүл мэнд төслүүдийг хэрэгжүүлнэ.	2013-2016	МТШХХГ	ЭМЯ	Төрийн байгууллага	25.0 сая ам.доллар ДБ-ны хөнгөлөлттэй зээл	Төслүүд хэрэгжсэн байна.
		2	Шуудангийн үндсэн сүлжээний техник технологийн шинэчлэл хийж, цахим шуудангийн үйлчилгээ бий болгоно	2013-2016	МТШХХГ		ХХ	21.050.0 Улсын төсөв	Шинэчлэл хийгдэж, цахим шуудангийн үйлчилгээтэй болсон байна.
		3	Цахим гарын үсгийн сертификатыг иргэний ухаалаг үнэмлэхэд суулгана.	2013-2015	МТШХХГ	УБЕГ		13.400.0 Улсын төсөв	Сертификатыг иргэний ухаалаг үнэмлэхэд суулгасан байна.
		4	Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа бүх шатны байгууллагуудын сүлжээнд мэдээллийн аюулгүй байдлын төхөөрөмж суурилуулна.	2013	МТШХХГ	Яам	ХХ	Улсын төсөв 2.980.0	Төхөөрөмж суурилуулсан байна.
		5	Төрийн бүх шатны байгууллага, түүний салбар нэгжүүдэд иргэний цахим үнэмлэх уншигч, тоног төхөөрөмж суурилуулж, программ хангамж нэвтрүүлнэ.	2013-2014	МТШХХГ	Яам	ХХ	15.300.0 Улсын төсөв	Төхөөрөмж суурилуулж, программ хангамжийг нэвтрүүлсэн байна.
		6	Засгийн газрын энтерпрайз архитектур боловсруулж, нэвтрүүлнэ.	2013	МТШХХГ	Яам	ХХ	Улсын төсөв 1.500.0	Энтерпрайз архитектурыг нэвтрүүлсэн байна.

		7	Хэвлэлийн электрон хүргэлтийн систем бий болгоно.	2013-2015	МТШХХГ		ХХ	1.050.0 Улсын төсөв	Систем бий болсон байна.
		8	Газар зүйн мэдээллийн санг ашиглах, мэдээлэл боловсруулалт хийх, шийдвэр гаргах үйл ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор газар зүйн мэдээллийн нэгдсэн платформыг хөгжүүлж хэрэглээг нэвтрүүлнэ.	2012-2014	МТШХХГ	БХБЯ	ХХ	3.000.0 Улсын төсөв	Төсөл хэрэгжиж эхэлсэн байна.
		9	Барилга, хот байгуулалтын салбарын үйл ажиллагааг иргэд, аж ахуйн нэгжүүдэд нээлттэй, ил тод, шуурхай болгох зорилгоор “Цахим салбар-барилга, хот байгуулалт” төслийг хэрэгжүүлнэ.	2012-2014	БХБЯ		ТББ	3.800.0 Улсын төсөв	Төсөл хэрэгжсэн байна.
		10	Өргөн нэвтрүүлгийг тоон технологид бүрэн шилжүүлнэ.	2012-2014	МТШХХГ		ХХ ХХЗХ	28.750.0	Тоон технологид шилжүүлсэн байна.
284.	Авлига, хүнд сурталтай хийх тэмцэлд эрс шинэчлэл гаргах	1	Авлигын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг төрийн захиргааны байгууллага бүр ажиллагсаддаа сурталчилж ажиллана.	2012-2016	АТГ	Яам агентлаг	АНЗД Төсөвт байгууллага		Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авагдсан байна.
		2	Иргэдэд үйлчилдэг байгууллага, албан тушаалтан, ажилтны овог нэр, хариуцсан ажлын чиг үүрэг (тусгай зөвшөөрөл, лиценз, тэтгэвэр, халамж, татвар), ажиллах цаг, уг ажилтай холбоотой хууль тогтоомж, журам, дүрмийн талаархи мэдээллийг иргэдэд нээлттэй байрлуулдаг болно.	2012-2013	Яам агентлаг	АТГ	АНЗД Төсөвт байгууллага		Ил тод байдал хангагдсан байна.
		3	Засгийн газар иргэдээ сонсдог “222” арга хэмжээг сар бүр, “11 11” төвийг байнга ажиллуулж, тэдний саналыг сонсож, холбогдох арга хэмжээ авч ажиллана.	2012-2016	ЗГХЭГ	Яам агентлаг	АНЗД		Нээлттэй байдал хангагдсан байна.
		4	Яамдын ажлын уялдаа холбоог сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилгоор сар бүрийн эцэст “Хариуцлага, Хэрэгжилт, Хяналт” арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлнэ.	2012-2016	ЗГХЭГ	Яам агентлаг	АНЗД		Хариуцлагын шинэ тогтолцоо бүрдсэн байна.
		5	Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу гаргаж тайлагнах үйл ажиллагааг хэвшүүлнэ.	2012-2016	АТГ	Яам Агентлаг	АНЗД Төсөвт байгууллага		Хууль тогтоомж хэрэгжсэн байна.
		6	Иргэдэд үзүүлэх үйлчилгээний шат дамжлагыг багасгах зорилгоор холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд өөрчлөлт оруулан боловсронгуй болгоно.	2012-2013	ЗГХЭГ	Холбогдох яам агентлаг	ХАБСТ		Хууль тогтоомж, дүрэм, журамд өөрчлөлт оруулсан байна.

		7	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийтийн үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн байгууллагаар дамжуулан иргэдэд хүргэх ажлыг эхлүүлнэ.	2012-2016	ЗГХЭГ	Холбогдох яам агентлаг	ХАБСТ		ТББ болон хувийн хэвшлээр үйлчилгээ үзүүлдэг болсон байна.
285.	Шүүх, хууль хяналтын байгууллагын тогтолцооны шинэчлэлт хийх	1	Шүүх, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг цогцоор нь шинэчлэн боловсруулна.	2012-2014	ХЗЯ				Шинэчлэлт хийгдэж эхэлсэн байна.
		2	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх нэгдсэн тогтолцоог үе шаттайгаар бүрдүүлнэ.	2012-2016	ХЗЯ				Тогтолцоо бүрдсэн байна.
286.	Дотоод хэргийн чиг үүрэг давамгайлсан байдлыг халах замаар Хууль зүйн яамны чиг үүрэг, зохион байгуулалтыг өөрчлөн боловсронгуй болгож, хууль зүйн бодлогыг шинжлэх ухааны үндэстэй, хүний эрх, эрх зүйт ёсны зарчимд нийцүүлэх механизмыг бий болгох	1	Хууль зүйн яамны чиг үүрэг, зохион байгуулалтыг өөрчлөн боловсронгуй болгож, хүний нөөцийг бэхжүүлэх, чадавхижуулах чиглэлээр үе шаттай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	2012-2014	ХЗЯ				Дотоод хэргийн чиг үүрэг, эрх нь агентлаг болон орон нутгийн түвшинд шилжсэн байна.
		2	Эрх зүйн шинэтгэлийн стратегийн баримт бичгийг боловсруулна.	2012-2013	ХЗЯ				Баримт бичгийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
287.	Төрийн албан тушаалтны эрх мэдлийг тодорхойлсон хууль зүйн бодлогыг өөрчилж, төрийн албыг нийтийн эрх ашгийг хамгаалж, иргэнд үйлчлэх нийтийн алба, иргэний алба болгон шинэчлэх	1	Төрийн байгууллага, албан тушаалтны эрх мэдлийг тодорхойлсон одоогийн хууль зүйн бодлогыг өөрчлөх талаар холбогдох хуулийн төсөл боловсруулна.	2013-2016	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
288.	Төрийн үйл ажиллагаанд иргэд бүхий л хэлбэрээр оролцдог байх бололцоог эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хийх	1	Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны шийдвэрийг боловсруулах шатанд иргэдийн оролцоог хангах чиглэлээр Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
289.	Хуулийн тухай хуулийг батлуулж, хуулийн хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийг үнэлдэг болох	1	Хуулийн тухай хуулийн төслийг боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		2	Хуулийн төслийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах тогтолцоог бий болгож, хуулийн төслийн үр нөлөө, хууль хэрэгжүүлснээр гарах зардлыг урьдчилан тооцоолох, хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх журмыг хуульчилна.	2013	ХЗЯ				Хуулийн тухай хуулиар зохицуулсан байна.
290.	Төрийн бүх шатны албан хаагчдын үүргийг тодорхой болгож, үүргийн биелэлтийг үндэслэн хариуцлага тооцдог болох	1	Нийтийн албан тушаалтны ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх тухай хуулийн төслийг боловсруулна.	2012-2016	ЗГХЭГ	ХЗЯ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

291.	Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх	1	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		2	Гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх, тэднийг хамгаалах чиг үүрэг бүхий нэгжийг байгуулна.	2013-2014	ХЗЯ	УДШ УЕП АТГ ТЕГ		10.000.0	Нэгж бий болсон байна.
		3	Гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, тэдгээрт дэмжлэг үзүүлнэ.	2013-2016	ХЗЯ	УДШ УЕП АТГ ТЕГ	ТББ	4.000.0	Гэрч, хохирогчид туслалцаа үзүүлэх зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, урамшуулал олгож эхэлсэн байна.
292.	Хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг хуульчдын ажил, мэргэжлийн ур чадварыг үнэлэх шалгуурын гол үзүүлэлт болгох	1	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах дүрэм, журамд хүний эрхийн төлөөх үйл ажиллагааг хуульчдын ажил мэргэжлийн ур чадварыг үнэлэх гол шалгуур үзүүлэлт болгон тусгана.	2013-2016	ХЗЯ				Шалгуур үзүүлэлтийг холбогдох дүрэм, журамд тусгасан байна.
293.	Ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхитай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох	1	Зөрчлийн тухай хуулийн төсөл боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг боловсруулж УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		2	Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
294.	Иргэний үндсэн эрхийн хяналтыг Үндсэн хуулийн цэцэд олгож иргэний үндсэн эрхийн баталгааг сайжруулах	1	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.	2013-2014	ХЗЯ	ҮХЦ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
295.	Хууль зүйн мэргэжлийн болон иргэний боловсролын тогтолцоог боловсронгуй болгож, мэргэжлийн хуульч бэлтгэх тогтолцоог шинэ шатанд гаргах. Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Иргэний боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	1	Хууль зүйн их, дээд сургуулиудыг олон улсын жишигт нийцсэн, зах зээлд эрэлт хэрэгцээтэй боловсон хүчин бэлтгэдэг сургалтын тогтолцоонд шилжүүлэх арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.	2013-2016	ХЗЯ	БШУЯ	ХСХолбоо Төсөл		Хууль зүйн их, дээд сургуулиудын сургалтын тогтолцоо шинэчлэгдсэн байна.
		2	Эрх зүйн бакалаврын стандартад өөрчлөлт оруулж, мөрдүүлнэ.	2012-2016	ХЗЯ	БШУЯ	ХСХолбоо		Стандартыг өөрчилж, мөрдүүлсэн байна.

		3	“Иргэний боловсрол” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2012-2016	БШУЯ	ХЗЯ			Хөтөлбөр хэрэгжсэн байна.
		4	Хууль зүйн дипломын бус боловсролын тогтолцоог нэвтрүүлнэ.	2013-2016	ХЗЯ				Хууль зүйн дипломын бус боловсролын тогтолцоо бий болсон байна.
296.	Хуульчдын мэргэжлийн өөрөө удирдах байгууллагыг байгуулж чадавхижуулах	1	Хуульчдын холбоог байгуулна.	2013-2014	ХЗЯ				Холбоо байгуулагдсан байна.
		2	Мэргэжлийн хуульчдын давтан сургалтын тогтолцоог бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	2013-2016	ХЗЯ			2.0	Тогтолцоо бүрдсэн байна.
297.	Иргэдэд өдөр тутам үйлчилдэг нийтийн албан хаагчдыг иргэд өөрсдөө үнэлдэг тогтолцоонд оруулж, цалин хангамжийг ажлын бүтээмжтэй уялдуулан тооцож, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	1	Нийтийн албаны байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, үр дүнг дээшлүүлэх зорилгоор тухайн байгууллагын үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжид иргэдийн сэтгэл ханамжид тулгуурлан аудит хийж үнэлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	2012-2016	ЗГХЭГ	ХЗЯ			Эрх зүйн орчин бүрдсэн байна.
298.	Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд хүнд сурталгүй, ил тод, алагчлалгүй, шударга, хүртэмжтэй болгох	1	Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг тусгайлан авч үзэж, Авлигын эсрэг НҮБ-ын Конвенцид нийцүүлэн боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
299.	Удирдлагын академийг нийтийн албан хаагчдын үргэлжилсэн сургалтын байгууллага болгон өөрчлөх	1	Удирдлагын академийг төрийн бодлогыг хэрэгжүүлэх талаар төр, захиргааны байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, нийтийн албан хаагчдыг сургах, давтан сургах, нийтийн албаны хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох талаар судалгаа, шинжилгээ хийх, сургалт зохион байгуулах чиг үүрэгтэй байгууллага болгон өөрчлөн зохион байгуулна.	2012	ЗГХЭГ		УА		Шинэ зохион байгуулалтаар ажилладаг болсон байна.
300.	Залуучуудын хөгжлийн асуудлаар үндэсний хэмжээнд бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Засгийн газрын Үндэсний хороог байгуулах	1	“Монгол залуу хүн” Үндэсний хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллуулна	2012-2016	ХАХНХЯ			1.000.0 Улсын төсөв	Үндэсний хороо байгуулагдаж хөтөлбөр хэрэгжсэн байна.
301.	Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хууль батлуулж, иргэний нийгмийн байгууллагын санхүүжилтийн шинэ хувилбаруудыг бий болгох	1	Нийтэд тустай үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулна.	2013-2014	ХЗЯ	ЕТГ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
302.	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодод шилжүүлэх ажлыг бодитойгоор хэрэгжүүлэх	1	Төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх тухай хуулийн төсөл боловсруулна.	2013-2014	ХЗЯ	ЕТГ			Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

		2	Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэхтэй холбогдуулан холбогдох хууль тогтоомж, шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах, Засгийн газрын агентлаг, улсын төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах зэрэг асуудлыг цогц байдлаар судалж шийдвэрлэнэ.	2012-2014	ЗГХЭГ	Яам агентлаг	ТББ		Тогтоол, шийдвэр батлагдаж хэрэгжсэн байна.
		3	Аудитын тухай хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад өөрчлөлт оруулах замаар аудитын үйл ажиллагаа, хөрөнгийн үнэлгээ хийх, тусгай зөвшөөрөл олгох болон мэргэшсэн нягтлан бодогчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагад шилжүүлнэ.	2012-2014	СЯ	ХЗЯ	ММНБИ ММҮИ		Тусгай зөвшөөрөл олгох ажиллагааг ТББ-аар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлдэг болсон байна.
303.	Нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, байгаль хамгаалал, хүүхдийн эрх, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч, дэд бүтэцтэй холбоотой асуудлыг шүүхэд нэхэмжлэн хамгаалах стратегийн өмгөөлөл, бодлогын нөлөөллийг бүх талаар дэмжих	1	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулна.	2013-2014	ХЗЯ				Хуулийн төслүүдийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
304.	Судалгаа, шинжилгээний ажлыг их, дээд сургууль болон бодлогын институт дээр төвлөрүүлж, Шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн санхүүжилтийг энэ зорилготой уялдуулах	1	Шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөөний зорилттой уялдуулан салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийг 2012-2016 онд үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	2012-2012	БШУЯ				Хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна.
		2	Шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийн хуваарилалтыг шинэчлэн, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын хөрөнгө, нөөц боломж, дагнах, хорших ажлын сонголтыг сайжруулан, хяналт-үр дүнг шинэ шатанд гаргана.	2012-2014	БШУЯ				Санхүүжилтийн хуваарилалт шинэчлэгдэн, хяналт-үр дүн сайжирсан байна.
		3	Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд патентийн мэдээллийг ашиглах нийтлэг журмыг тогтоож, мөрдүүлнэ.	2013	ОӨГ	БШУЯ	ШУА	0.05 Улсын төсөв	Журмыг батлан, мөрдүүлсэн байна.
		4	Эдийн засаг, нийгмийн эрэлт хэрэгцээг хангасан оюуны өмчийг бий болгоход чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ	2014	БШУЯ ОӨГ	СЯ	ШУА	0.05 Улсын төсөв	Тогтолцоо бүрдсэн байна.
305.	Салбарын мэргэшсэн хяналтын байгууллага бий болгох	1	Мэргэжлийн хяналтын байгууллагыг өөрчлөн зохион байгуулахтай холбогдуулан хяналт шалгалтын хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	2012-2013	ЗГХЭГ	ХЗЯ МХЕГ Холбогдох яам агентлаг			Хууль тогтоомжийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		2	Хяналт, шалгалтын зориулалттай лабораторийг материалын лаборатори	2012-1016	МХЕГ	СЯ Холбогдох	АНЗД		Лабораторийн хяналт

			болгон бэхжүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.			яам			сайжирсан байна.
		3	Төвсийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитор, хяналт шалгалтын улсын байцаагчдыг сургаж, мэргэшүүлнэ.	2013-2014	СЯ	Яам агентлаг	АНЗД	Улсын төсөв Гадаадын зээл, тусламж	Сургалтыг зохион байгуулсан байна.
		4	Салбарын хяналтын байцаагчдыг хариуцсан асуудлын чиглэлээр давтан сургаж, мэргэшүүлнэ.	2013-2014	Бүх яам	Агентлаг	АНЗД ТББ	Улсын төсөв Гадаадын зээл, тусламж	Сургалтыг зохион байгуулсан байна.
306.	Шүүхийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг нээлттэй болгох	1	Шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэл, прокурор, Хууль зүйн яам, цагдаа, мөрдөх албаны мэдээллийн цахим сүлжээ бий болгоно.	2013-2014	ХЗЯ			300.0	Цахим сүлжээ ажиллуулж эхэлсэн байна.
		2	Хууль зүйн нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлнэ.	2013-2014	ХЗЯ			300.0	Нэг цонхны үйлчилгээг нэвтрүүлсэн байна.
307.	Шүүхийг тойргийн тогтолцоогоор шинэчлэн зохион байгуулахтай уялдуулан прокурор, өмгөөлөл, мөрдөх албаны зохион байгуулалт, үйл ажиллагааг шинэчлэх	1	Мөрдөх албыг шинээр зохион байгуулахтай холбогдуулан хуулийн төсөл боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		2	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		3	Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төсөл боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
308.	Шүүхэд мөрдөн байцаалтын шатны шүүгчийн бүтцийг бий болгож, хүний эрхийн баталгааг дээшлүүлэх	1	Шүүхэд мөрдөн байцаалтын шатны шүүгчийн орон тоог бий болгох, хүний эрхийн баталгааг дээшлүүлэх чиглэлээр холбогдох хуулийн төслийг боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
309.	Шүүн таслах ажиллагааг захиргааны үйл ажиллагаанаас тусгаарлаж, шүүхийн захиргааг мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлэх	1	Шүүхийн захиргаа, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон стандарт, дүрэм, журмыг батлан мөрдүүлнэ.	2013-2015	ХЗЯ	ЕТГ ШЕЗ			Стандарт, дүрэм, журмыг батлан мөрдүүлсэн байна.
310.	Шүүх, шүүгчийн хамгаалалт, шүүгдэгчийг албадан авчрах, гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, хорихоос оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах, хуяглан хүргэх зэрэг чиг үүрэг бүхий тусгай албыг бий болгож, эрүүгийн хэргийн болон иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийг ялгавартай зохион байгуулах	1	Шүүх, шүүгчийн хамгаалалт, шүүгдэгчийг албадан авчрах, гэрч, хохирогчийг хамгаалах, шүүх, хорихоос оргон зайлсан этгээдийг эрэн сурвалжлах, хуяглан хүргэх зэрэг чиг үүрэг бүхий тусгай албаны тухай хуулийн төслийг боловсруулна.	2013	ХЗЯ	ШЕЗ		1.000.0	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		2	Тусгай албаны бүтэц, орон тоог тогтоож, холбогдох эрхийн актуудыг боловсруулж батална.	2013-2014	ХЗЯ	ШЕЗ		100.0	Тусгай алба байгуулагдсан байна.
		3	Эрүүгийн хэргийн болон Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх чиг үүргийг	2013-2014	ХЗЯ			300.0	Хуулийн төслийг УИХ-д өргөн

			салгаж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай багц хуулийг шинэчлэн боловсруулна.						мэдүүлсэн байна.
311.	Прокурорын байгууллагын хүний эрхийн болон гүйцэтгэх ажлын хяналт, процессын маргаан шийдвэрлэх чиг үүргийг шүүхэд шилжүүлэх	1	Хүний эрхийн болон гүйцэтгэх ажлын хяналт, процессын маргаан шийдвэрлэх чиг үүргийг шүүхэд шилжүүлэх чиглэлээр хуулийн төсөл боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
312.	Захиргааны болон эрүүгийн зөрчлийг бүртгэх нэгдсэн сан бий болгож, эргүүлийн цагдаа, хилийн алба, татвар, бусад мэргэжлийн хяналтын үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагын менежментийг нэвтрүүлэх	1	Гэмт хэрэг, зөрчлийг бүртгэх нэгдсэн сан байгуулж, хууль сахиулах байгууллагуудын сүлжээнд холбох ажлыг үе шаттай зохион байгуулна.	2013-2014	ХЗЯ			300.0	Нэгдсэн сан байгуулж, сүлжээнд холбосон байна.
		2	Хууль сахиулах болон хяналтын байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлийн менежмент нэвтрүүлэх арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.	2013-2014	ХЗЯ	МХЕГ		100.0	Эрсдэлийн менежментийг байна.
313.	Мөрдөн байцаах, эрүүгийн цагдаагийн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтыг мөрдөх алба болгон нэгтгэн зохион байгуулж, мөрдөх албаны дэргэд шүүхийн шинжилгээний бүтцийг бий болгох	1	Мөрдөх албыг шинээр зохион байгуулна.	2013-2014	ХЗЯ				Мөрдөх албыг байгуулсан байна.
314.	Цагдаагийн байгууллагад гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх мэргэшсэн нэгж байгуулах	1	Цагдаагийн байгууллагын бүтцэд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх мэргэшсэн нэгж байгуулах талаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.	2013-2014	ХЗЯ			2.000.0	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
315.	Цагдаагийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүргийг орон нутгийн эрх мэдлийн түвшинд зохион байгуулах	1	Нийслэлийн нутаг дэвсгэрийг хэсэгчилсэн тойрогт шилжүүлж, тойрог бүрт ажиллах цагдаагийн байр, цагдаагийн хүч, хэрэгсэл, техникийн хангамжийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.	2014	ХЗЯ		НЗД ОУБ	4.0	Үе шаттайгаар шилжүүлсэн байна.
		2	Нийслэл, аймгийн төвүүдийг камерийн хяналтын системд үе шаттайгаар шилжүүлэх ажлыг зохион байгуулна.	2013-2015	ХЗЯ		АНЗД ОУБ	300.0	Камерийн хяналтын системд шилжсэн байна.
		3	Орон нутаг дахь сумдын хэсгийн төлөөлөгч нарыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	2013-2016	ХЗЯ		АНЗД ОУБ	150.0	Сумдын төлөөлөгч нар сүлжээнд холбогдсон байна.
316.	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хувь эзэмшил, орлогыг ил тод болгож, хэвлэлийн байгууллагуудын бие даасан байдлыг дээшлүүлж, иргэний хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулах	1	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төслийг боловсруулна.	2013-2014	ХЗЯ			30.0	Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
		2	Хэвлэл мэдээллийн хэрэгслийг бүртгэх үйл ажиллагааг нийтэд ил тод, чирэгдэлгүй болгох арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.	2012-2014	ХЗЯ		ТББ	40.0	Бүртгэлийн үйл ажиллагаа нээлттэй, түргэн шуурхай болсон байна.

317.	Шүүхийн шинэтгэлийн багц хуулиудын хэрэгжилтийг хангах техник, зохион байгуулалтын арга хэмжээг цогцоор нь төлөвлөж шийдвэрлэх	1	Шүүхийн багц хуулийн хэрэгжилтийг үе шаттайгаар зохион байгуулна.	2014-2016	ХЗЯ	ЕТГ УДШ ШЕЗ			Хууль хэрэгжиж эхэлсэн байна.
		2	Эрүүгийн хууль, Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах үйл ажиллагааны тухай, Мөрдөх албаны тухай, Цагдаагийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай, Цагдаагийн байгууллагын тухай хуулиудыг хэрэгжүүлэх зорилгоор бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, техникийн холбогдох арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.	2014-2016	ХЗЯ			30.000.0	Хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулсан байна.
318.	Шүүхээс гадуур хүний эрхийг хязгаарлаж, эрүүгийн хэргийг байцаан шалгадаг тогтолцоог халж, шүүхийн хяналтын дор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох	1	Шүүхийн хяналтын дор эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох чиглэлээр хуулийн төсөл боловсруулна.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.
319.	Хээл хахууль, шан харамжийг ялгамжтай зохицуулж, хахууль өгсөн талыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, хөнгөлөх асуудлыг хуульчлах	1	Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулахдаа хээл хахууль, шан харамжийг ялгамжтай зохицуулж, хахууль өгсөн этгээд хэргээ илчилсэн тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, хөнгөлөх талаар тусгана.	2013	ХЗЯ				Хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна.

ТОВЧИЛСОН НЭРИЙН ТАЙЛАЛ

(Цагаан толгойн үсгийн дараалаар)

ЕТГ-	Ерөнхийлөгчийн Тамгын газар
ЗГХЭГ-	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
УИХТГ -	Улсын Их Хурлын Тамгын газар
УДШ -	Улсын дээд шүүх
УЕП -	Улсын ерөнхий прокурор
ҮХЦ -	Үндсэн хуулийн цэц
ШЕЗ -	Шүүхийн ерөнхий зөвлөл

Яам

БОНХЯ -	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам
БХБЯ -	Барилга, хот байгуулалтын яам
БХЯ -	Батлан хамгаалах яам
БШУЯ -	Боловсрол, шинжлэх ухааны яам
ГХЯ -	Гадаад харилцааны яам
ЗТЯ -	Зам, тээврийн яам
СЯ -	Сангийн яам
ССАЖЯ -	Соёл, спорт, аялал жуулчлалын яам
УУЯ -	Уул уурхайн яам
ҮХААЯ -	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ХЯ -	Хөдөлмөрийн яам
ХЗЯ -	Хууль зүйн яам
ХАХНХЯ -	Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам
ЭЗХЯ -	Эдийн засгийн хөгжлийн яам
ЭХЯ -	Эрчим хүчний яам
ЭМЯ -	Эрүүл мэндийн яам

Засгийн газрын агентлаг, бусад байгууллага

АТГ -	Авлигатай тэмцэх газар
АЗД -	Аймгийн Засаг дарга
АНЗД -	Аймаг, нийслэлийн Засаг дарга
ГЕГ -	Гаалийн ерөнхий газар
ДЗ -	Далайн захиргаа
ДТГ -	Дипломат төлөөлөгчийн газар
ЗГХК -	Засгийн газар хоорондын комисс
ИНЕГ -	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИТХ -	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МТШХХГ -	Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар
МХЕГ -	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НЗД -	Нийслэлийн Засаг дарга
ОБЕГ -	Онцгой байдлын ерөнхий газар
ОӨГ -	Оюуны өмчийн газар
СХЗГ -	Стандартчилал, хэмжил зүйн газар
СЗХ -	Санхүүгийн зохицуулах хороо
СӨТ -	Соёлын өвийн төв
ТЕГ -	Тагнуулын ерөнхий газар
ТГЗ -	Туул голын захиргаа
УБЕГ -	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УА -	Удирдлагын академи
ҮАГ -	Үндэсний аудитын газар
ҮСХ -	Үндэсний статистикийн хороо
ХААГ -	Худалдан авах ажиллагааны газар
ХХЗХ -	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХХЕГ -	Хил хамгаалах ерөнхий газар
ХЭҮК -	Хүний эрхийн үндэсний комисс
ЦЭГ -	Цөмийн энергийн газар
ШӨХТГ -	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар

Сангууд

БХС - Байгаль хамгаалах сан
БСННС - Барилгын салбарын норм, нормативын сан
ЗХХС - Зэвсэгт хүчний хөгжлийн сан
ЗБДС - Зээлийн батлан даалтын сан
ЖДҮХС - Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
МБСДС - Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан
НДС - Нийгмийн даатгалын сан
ХЭДС - Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ШУТС - Шинжлэх ухаан, технологийн сан
ЭМДС - Эрүүл мэндийн даатгалын сан

Төрийн бус байгууллага болон бусад

ААН - Аж ахуйн нэгж
АХБ - Азийн хөгжлийн банк
БХИС - Батлан хамгаалахын их сургууль
ГХО - Гадаадын хөрөнгө оруулалт
ДБ - Дэлхийн банк
“ДТҮ” ТӨХК - “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” Төрийн өмчит хувьцаат компани
ЖАЙКА - Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
ИНБ - Иргэний нийгмийн байгууллага
ИДС - Их, дээд сургууль
ИСХ - Их сургуулиудын холбоо
МИҮТ - Магадлан итгэмжлэлийн үндэсний төв
МУСҮТ - Малын удмын сангийн үндэсний төв
МБОИЗ - Монголын байгаль орчны иргэний зөвлөл
ММНБИ - Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт
ММҮИ - Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт
МҮМЭХ - Монголын үндэсний мал эмнэлгийн холбоо
МҮХАҮТ - Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим
МЭҮТ - Мал эмнэлгийн үржлийн тасаг

МАОЭНХ -	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо
МБХ -	Монголын банкуудын холбоо
МХБ -	Монголын хөрөнгийн бирж
МУИС -	Монгол улсын их сургууль
МҮЭХ -	Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбоо
МҮҮХХ -	Монголын үйлдвэрлэл үйлчилгээний хоршоодын холбоо
МХҮНХ -	Монголын хоршооллын үндэсний нэгдсэн холбоо
МБСҮЗ -	Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл
МБСБ -	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МСС -	Мянганы сорилтын сан
НДҮЗ -	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НАА -	Нийтийн аж ахуйн байгууллага
НҮБ -	Нэгдсэн Үндэстний Байгууллага
НҮБХХ -	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ОУБ -	Олон улсын байгууллага
СЭХҮТ -	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв
ТББ -	Төрийн бус байгууллага
ТХХТ -	Төр, хувийн хэвшлийн түншлэл
ТЕЗ -	Төсвийн ерөнхийлөн захирагч
УМЭАЦТЛ -	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
ҮТА -	Үндэсний тагнуулын академи
ХНМӨСҮТ -	Хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн өвчин судлалын төв
ХААИС -	Хөдөө аж ахуйн их сургууль
ХБ -	Хөгжлийн банк
ХО -	Хөрөнгө оруулагч
ХХ -	Хувийн хэвшил
ХХО -	Хувийн хөрөнгө оруулалт
ХАБСТ -	Хүний аюулгүй байдлын судалгааны төв
ШУА -	Шинжлэх ухааны академи
ШУТИС -	Шинжлэх ухаан, технологийн их сургууль